



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 06 өдөр

Дугаар А/545

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Соёлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6, 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 204 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх журам", Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/222 дугаар тушаал, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2025 оны 26 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Ардын уран зохиолч, Соёлын гавьяат зүтгэлтэн, Төрийн шагналт Лодонгийн Түдэвийн мэндэлсний 90 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээнд хөрөнгө зарцуулсугай.

2. Арга хэмжээний зардалд шаардагдах 6.000.000 (зургаан сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

